



СЭЛЭНГЭ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2019

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
ОРШИЛ.....	5
ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ	6
ХАМРАХ ХҮРЭЭ	7
I.АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	8
I.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ	9-12
I.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛАЛТ	13-14
II. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТЫН ХАМААРАЛ	15
III. БАРИЛГА.....	16
IV. ТЭЭВЭР	17
V. ДҮГНЭЛТ.....	18
АШИГЛАСАН МАТЕРИАЛ, НОМ ЗҮЙ.....	19

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, салбараар, сая.төг	2
ХҮСНЭГТ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, сумдаар, сая төгрөгөөр.....	8
ХҮСНЭГТ 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛАЛТ, салбараар, сая.төг.....	12
ХҮСНЭГТ 4. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ БОРЛУУЛАЛТЫН ХАМААРАЛ	14
ХҮСНЭГТ 5. БАРИЛГЫН САЛБАРТ ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, төрлөөр, сая.төг.....	15
ХҮСНЭГТ 6. ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН ТЭЭВРИЙН ТОО, төрлөөр.....	15

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ	7
ЗУРАГ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, тэрбум төгрөгөөр.....	9
ЗУРАГ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТЭД ДЭД САЛБАРЫН ЭЗЛЭХ ХУВЬ, тэрбум төгрөгөөр.....	9
ЗУРАГ 4. 2019 ОНД АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН САРЫН МЭДЭЭНД ХАМРАГДСАН ААНБ-ЫН ТОО, сумдаар	10
ЗУРАГ 5. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, биет хэмжээгээр	11
ЗУРАГ 6. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөгөөр..	13
ЗУРАГ 7. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛТАНД ДЭД САЛБАРЫН ЭЗЛЭХ ХУВЬ.....	13

ОРШИЛ

Аливаа улс орны хөгжлийн гол тулгуур нь аж үйлдвэрийн хөгжил байдаг. Сэлэнгэ аймаг нь газар тариалан голлон хөгжүүлсэн аймаг бөгөөд 106 854 суурин хүн амтай, 41 152.63км² гаүр нутагтай Монгол улсын хойд хэсэг Орхон Сэлэнгийн сав газар оршидог. Хойд талаараа Оросын Холбооны Улс, баруун талаараа Булган, Орхон, өмнө талаараа Төв, зүүн талаараа Хэнтий аймгуудтай хил залгадаг. Нутаг дэвсгэрийн төв хэсэгтээ Дархан-Уул аймгийг багтааж байдаг. Улсын нийслэл Улаанбаатар хот, төвийн бүсийн аймгуудтай олон улсын төмөр зам, хатуу хучилттай авто замаар холбогдсон, гол мөрний усан замын тээвэр ашиглах уламжлалт бололцоотой, дэд бүтэц давуу хөгжсөн аймаг билээ.

Сэлэнгэ аймгийн аж үйлдвэрийн салбарыг дотор нь :

- Уул уурхай олборлох аж үйлдвэр үүнд: Төмрийн хүдэр, нүүрс, алт зэрэг ашигт малтмалын олборлолт, борлуулалт
- Боловсруулах аж үйлдвэр үүнд: Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, мод, модон эдлэл үйлдвэрлэл, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн /цемент, шохой, блок, тоосго гэх мэт / бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт
- Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж үүнд: Дулаан, цахилгаан, ус хангамж үйлдвэрлэлт, борлуулалт

Манай аймаг аж үйлдвэрийн салбарт 40 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэж байгаагаас төмрийн хүдэр, алт, цемент, шохой, дулаан, зүсмэл, архи, спирт, нарийн боов, талх зэрэг гол нэр төрлийн 10 гаруй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нийт үйлдвэрлэлд 95 гаруй хувийг эзэлж байна.

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Аж үйлдвэрийн салбарын статистикт дараах ойлголт, тодорхойлолтыг ашигладаг.

Ойлголт	Тодорхойлолт
Нийт үйлдвэрлэл	Тайлант хугацаанд шинээр үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний нийт дүн (тухайн оны үнээр)-г хэлнэ.
Завсрын хэрэглээ	Үйлдвэрлэл, үйлчилгээний явцад орц болж зарцуулагдсан бүтээгдэхүүний зардал (худалдан авсан барааны өртгөөс жилийн эцсийн нөөцийн өөрчлөлтийг хасна) болон үйлчилгээний төлбөрийг хэлнэ.
Нэмэгдэл өртөг	Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хассан дүнг хэлнэ. Нийт үйлдвэрлэлийн үндсэн үнээр, завсрын хэрэглээг худалдан авагчийн үнээр үнэлнэ.
Бүтээгдэхүүн борлуулалт	Тайлант хугацаанд худалдсан буюу бусдад зориулж гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хэлнэ. Нийт борлуулалтад тухайн үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалтад орно. Хэрэв захиалагч бүтээгдэхүүнийхээ төлбөрийг урьдчилан төлсөн бол уг бүтээгдэхүүнийг борлуулагдсан гэж үзнэ.
Аж үйлдвэрийн борлуулалт	Зөвхөн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг хамруулна. Энд үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээ, үндсэн хөрөнгө, түүхий эд материал зэргийн худалдан борлуулсан хэмжээг хамруулахгүй.
Бүтээгдэхүүн	Үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон бараа, үйлчилгээг хэлнэ.
Гол нэрийн бүтээгдэхүүн	Тайлант хугацаанд үйлдвэрлэсэн салбарын үйлдвэрлэлийг төлөөлөхүйц бүтээгдэхүүнийг хэлнэ.
Ажиллагч	Тайлант хугацаанд ажиллагчид (цалин хөлстэй ажиллагч болон цалин хөлсгүй ажиллагч)-ийн ажилласан цагийг хэлнэ.
Ажилласан цаг	Тайлант хугацаанд ажиллагчид (цалин хөлстэй ажиллагч болон цалин хөлсгүй ажиллагч)-ийн ажилласан цагийг хэлнэ.
Үйлдвэрлэлийн индекс	Үнийн өөрчлөлтийн нөлөөллийг арилгасан биет хэмжээний өөрчлөлтийг илэрхийлэх индексийг хэлнэ.

ХАМРАХ ХҮРЭЭ

Салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг тооцохдоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээг үндсэн буюу үйлдвэрлэгчийн үнээр тооцдог бөгөөд бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэлийн өөрчлөлтийг мөн үнэлж тусгадаг. Нийт үйлдвэрлэлээс бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан зардлын хэмжээг хасаж, тайлант хугацаанд шинээр бий болсон нэмэгдэл өртгийн хэмжээг дэд салбаруудаар тооцож байна. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг тооцох мэдээллийн эх үүсвэр нь бизнес регистрийн санд бүртгэлтэй аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны тайлан болон холбогдох захиргааны статистик мэдээлэл болно. Мэдээллийг сарын болон жилийн давтамжтайгаар цуглуулж, холбогдох тооцооллыг хийдэг.


Сарын давтамжтайгаар: “Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ”-ний маягтаар аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудын гүйцэтгэлийг биет хэмжээ, үнийн дүнгээр тухайн сарын болон жилийн өссөн дүнг цуглуулдаг. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг оны үнээр, бүтээгдэхүүний борлуулалтыг, үүнээс гадаад, дотоодын борлуулалт, нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний тухайн сард борлогдоогүй үлдэгдэл, ажиллагчдын тоо, ажилласан цаг зэрэг үзүүлэлтийг тооцдог.

Жилийн давтамжтайгаар: “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээ”, “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны хураангуй мэдээ” гэсэн маягтаар тухайн ААНБ-ын орлого, зарлагын дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулан нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийг тооцож байна.

I. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Аж үйлдвэрийн салбар нь манай аймгийн төдийгүй улсын эдийн засгийн хөгжилд голлох байр суурь эзэлдэг билээ. Сэлэнгэ аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 776.3 тэрбум төгрөг бөгөөд 376.5 тэрбум төгрөг буюу 48.5 хувийг аж үйлдвэрийн салбар бүрдүүлж байна.

**ЗУРАГ 1. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН
НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ**



ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 2010 онд 61.8 хувь байсан бол 2013 онд 46.3 хувьд хүртлээ буурч, 2014 онд 48.3 хувь болж өсч, 2015 онд 47.7 хувь болж буурч байгаад 2016, 2017 онуудад өсч 51.2 хувьд хүрсэн үзүүлэлтэй байна.

Аж үйлдвэрийн салбарын 2019 оны нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувийг 2017 онтой харьцуулахад 2.7 пунктээр бага, 2018 онтой харьцуулахад 0.5 пунктээр их байна.


I.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

2019 оны жилийн эцсийн байдлаар аж үйлдвэрийн салбарт 462.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийгдсэн нь урьд оны мөн үеэс 85.1 (22.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 62.7 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт, 35.2 хувь нь боловсруулах салбарт, 2.1 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт бүтээгджээ.

ХҮСНЭГТ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, салбараар, сая.төг

Салбараар	2016 I-XII	2017 I-XII	2018 I-XII	2019 I-XII	Нийт дүнд эзлэх хувь				2019 I-XII 2018 I-XII
					2016 I-XII	2017 I-XII	2018 I-XII	2019 I-XII	
Бүгд	303 898.3	305 803.4	377 024.8	462 154.1	100.0	100.0	100.0	100.0	122.6
Уул, уурхай, олборлох аж үйлдвэр	180 211.2	166 706.1	221 998.0	289 588.9	59.3	54.5	58.9	62.7	130.4
Чулуун нүүрс үйлдвэрлэл	-	-	-	1 694.8	-	-	-	0.6	-
Металлын үйлдвэрлэл	180 211.2	166 706.1	221 998.0	287 894.1	100.0	100.0	100.0	99.4	129.7
Боловсруулах аж үйлдвэр	117 454.8	132 089.5	146 548.6	162 554.7	38.6	43.2	38.9	35.2	110.9
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	70 855.0	78 943.0	99 541.4	102 896.6	60.3	59.8	67.9	63.3	103.4
Мод, мод эдлэл үйлдвэрлэл	640.1	1 040.9	1 718.8	1 581.8	0.9	1.3	1.7	1.5	92.0
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	44 668.4	51 435.5	44 710.0	57 092.8	38.0	38.9	30.5	35.1	127.7
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	6 232.3	7 007.8	8 478.2	10 010.5	2.1	2.3	2.2	2.1	118.1

ЗУРАГ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ,
тэрбум төгрөгөөр



Аж үйлдвэрийн салбарын 2019 оны нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг 2009 онтой харьцуулахад 146.1 (46.2%) тэрбум төгрөгөөр өсч, 2014 онтой харьцуулахад 219.3 (32.2%) хувиар буурсан бол 2017 оноос 158.3 (51.1%), 2018 оноос 85.1 (22.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТЭД ДЭД САЛБАРЫН ЭЗЛЭХ ХУВЬ



Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэд уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын эзлэх хувийг 2009 оноос 2019 оны хооронд авч үзвэл 2017 онд хамгийн бага буюу 54.5 хувь байсан бол 2011 онд хамгийн их буюу 87.9 хувь байжээ. Харин боловсруулах салбарын эзлэх хувь 2011 онд хамгийн бага буюу 11.3 хувь, 2017 онд хамгийн их буюу 43.2 хувьд хүрч байсан бол цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын эзлэх хувь 2012, 2014 онуудад хамгийн бага буюу 0.8 хувь, 2017 онд хамгийн их буюу 2.3 хувь байна.

ХҮСНЭГТ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, сумдаар, сая төгрөгөөр

Сум	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Нийт	385 336.5	303 898.2	305 803.4	377 024.8	462 154.1
Алтанбулаг	-	-	6.0	85.3	129.9
Ерөө	233 745.3	180 440.2	166 451.2	222 302.2	288 657.3
Зүүнбүрэн	11.8	-	-	3.7	7.3
Мандал	74 504.8	72 338.6	74 147.7	98 641.7	103 290.1
Орхон	-	-	-	-	-
Сант	4.2	2.9	30.2	40.3	40.3
Цагааннуур	50.1	190.8	221.3	127.8	20.8
Баянгол	31 030.3	684.7	5 068.5	2 471.8	788.7
Сайхан	40 634.0	46 056.7	54 041.3	45 553.0	60 355.1
Орхонтуул	21.8	5.6	41.2	23.8	30.9
Баруунбүрэн	15.6	-	42.7	9.2	6.7
Шаамар	331.6	-	4.5	164.6	126.5
Хүдэр	180.7	167.7	277.9	409.9	283.4
Сүхбаатар	4 783.1	4 007.6	5 459.3	7 120.0	6 690.6
Жавхлант	-	-	-	-	-
Түшиг	13.6	2.9	-	47.8	1 694.8
Хушаат	9.6	0.5	11.6	23.7	31.7

2019 оны аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг сумдаар авч үзвэл Ерөө сум дангаараа аймаг нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 62.5 хувь буюу 288.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол Мандал сум 22.3 хувь буюу 103.3 тэрбум төгрөг, Сайхан сум 13.1 хувь буюу 60.4 тэрбум төгрөг, Сүхбаатар сум 1.4 хувь буюу 6.7 тэрбум төгрөг, бусад сумд 0.7 хувь буюу 3.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

Ерөө суманд “Болд төмөр Ерөө гол” ХХК, Мандал суманд “Спирт бал бурам” ХХК, Сайхан суманд “Цемент шохой” ХК зэрэг томоохон аж ахуй нэгж байгууллагууд үйл ажиллагаа явуулж байгаа нь эдгээр сумдын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн эзлэх хувь өндөр байгаад нөлөөлж байна.

ЗУРАГ 4. 2019 ОНД АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН САРЫН МЭДЭЭНД ХАМРАГДСАН ААНБ-ЫН ТОО, сумдаар



**ЗУРАГ 5. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭРИЙН
БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, биет хэмжээгээр**



Төмрийн хүдэр
3 612.5 мян.тн




Алт
0.9 кг



Хүрэн нүүрс
84.7 мян.тн



Цемент
386.7 мян.тн



Шохой
53 299.0 тн



Дулаан эрчим хүч
147.4 мэгк



Зүсмэл материал
8 388.8 м3



Архи
9 274.9 мян.л



Спирт
3 462.3 мян.л



Талх, нарийн боов
248.8 тн


I.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛАЛТ

2019 оны жилийн эцсийн байдлаар аж үйлдвэрийн салбарт 515.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулалт хийгдсэн нь урьд оны мөн үеэс 124.4 (31.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн борлуулалтын 63.6 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт, 34.4 хувь нь боловсруулах салбарт, 1.9 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт бүтээгджээ.

ХҮСНЭГТ 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛАЛТ, салбараар, сая.төг

Салбараар	2016 I-XII	2017 I-XII	2018 I-XII	2019 I-XII	Нийт дүнд эзлэх хувь				2019 I-XII 2018 I-XII
					2016 I-XII	2017 I-XII	2018 I-XII	2019 I-XII	
Бүгд	299 224.6	394 086.1	390 714.5	515 090.5	100.0	100.0	100.0	100.0	131.83
Уул, уурхай, олборлох аж үйлдвэр	182 405.8	239 832.5	222 539.0	327 700.8	61.0	60.9	57.0	63.6	147.26
Чулуун нүүрс үйлдвэрлэл	100.9	711.9	5.6	2 398.6	0.1	0.3	0.0	0.7	-
Металлын үйлдвэрлэл	182 304.9	239 120.6	222 533.4	325 302.2	99.9	99.70	100.0	99.27	146.18
Боловсруулах аж үйлдвэр	110 586.5	147 117.2	160 303.3	177 374.0	37.0	37.3	41.0	34.4	110.65
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	55 258.4	93 754.0	105 194.1	108 040.5	46.8	63.7	65.6	60.9	102.71
Мод, мод эдлэл үйлдвэрлэл	283.7	1 544.9	2 233.5	1 806.4	0.3	1.1	1.4	1.0	80.88
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	54 305.7	51 212.3	51 884.9	66 651.7	44.9	34.8	32.4	37.6	128.46
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	6 232.3	7 136.4	7 872.2	10 015.7	2.1	1.8	2.0	1.9	127.23

**ЗУРАГ 6. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛАЛТ,
тэрбум төгрөгөөр**



Аж үйлдвэрийн салбарын 2019 оны нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг 2010 онтой харьцуулахад 301 (2.4*) тэрбум төгрөгөөр, 2014 онтой харьцуулахад 173.8 (50.9%) тэрбум төгрөгөөр, 2017 оноос 121 (30.7%), 2018 оноос 124.4 (31.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

**ЗУРАГ 7. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛАЛТАНД ДЭД
САЛБАРЫН ЭЗЛЭХ ХУВЬ**



Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн борлуулалтанд уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын эзлэх хувийг 2010 оноос 2019 оны хооронд авч үзвэл 2018 онд хамгийн бага буюу 57.0 хувь байсан бол 2012 онд хамгийн их буюу 80.4 хувь байжээ. Харин боловсруулах салбарын эзлэх хувь 2012 онд хамгийн бага буюу 18.2 хувь, 2018 онд хамгийн их буюу 41.0 хувьд хүрч байсан бол цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын эзлэх хувь 2011 онд хамгийн бага буюу 1.1 хувь, 2016 онд хамгийн их буюу 2.1 хувь байна.

I.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТЫН ХАМААРЛЫН СУДАЛГАА

ХҮСНЭГТ 4. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ БОРЛУУЛАЛТЫН ХАМААРАЛ

Он	Үйлдвэрлэлт – х тэрбум төг	Борлуулалт –у тэрбум төг	х*у	х ²
2009	316.1	88.9	28101.29	99919.21
2010	342.2	214.1	73265.02	117100.8
2011	484	366.8	177531.2	234256
2012	557.4	345.8	192748.9	310694.8
2013	468.1	265.1	124093.3	219117.6
2014	681.5	341.3	232596	464442.3
2015	385.3	287.6	110812.3	148456.1
2016	303.9	299.2	90926.88	92355.21
2017	305.8	394.1	120515.8	93513.64
2018	377	390.7	147293.9	142129
2019	462.2	515.1	238079.2	213628.8
Нийт дүн	4683.5	3508.7	1535964	2135613
Дундаж	425.8	319.0	139633.1	194146.7

$$\widehat{\beta}_0 = \bar{y} - \widehat{\beta}_1 * \bar{x} = 319.0 - 0.295615 * 425.8 = 193.1272$$

$$\widehat{\beta}_1 = \frac{\overline{xy} - \bar{x} * \bar{y}}{\overline{x^2} - \bar{x}^2} = \frac{139633.1 - 425.8 * 319.0}{194146.7 - 181282.4} = 0.295615$$

Сэлэнгэ аймгийн аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт борлуулалтыг сүүлийн 10 жилийн байдлаар харахад жилд дундажаар 425.8 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 319.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна. Энэ үзүүлэлт нь үйлдвэрлэлтээс борлуулалт бага байна гэж харагдах ба үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний өртөгийг нөхөөд ашиг буюу өндөр үнээр зарж борлуулж чадахгүй, нөгөөтэйгүүр үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ борлуулж чадахгүй үлдэгдэлтэй байгаа нь 106.8 тэрбумын зөрүүг харуулж байна.

II. БАРИЛГА

2019 онд Сэлэнгэ аймагт 41 790.3 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь өмнөх оны мөн үеэс 28 573.7 сая төгрөг буюу 3.2 дахин өссөн байна. Нийт барилга угсралт их засварын ажлын 5.1 хувийг орон сууцны барилга, 20.3 хувийг орон сууцны бус барилга, 67.3 хувийг инженерийн барилга байгууламж, 7.3 хувийг их засварын ажил эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. БАРИЛГЫН САЛБАРТ ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, төрлөөр, сая.төг

Барилгын төрөл	2015	2016	2017	2018	2019
Бүгд	35 807.3	10 333.4	91 591.2	13 216.6	41 790.3
Орон сууцны барилга	10 024.5		1 525.2	2 449.4	2 143.0
Орон сууцны бус барилга	22 270.7	8 851.4	6 279.3	3 738.9	8 479.4
Инженерийн барилга, байгууламж	1 611.5	618.9	81 301.9	1 912.0	28 135.1
Их засварын ажил	1 900.6	863.1	2 484.8	5 116.3	3 032.8

III. ТЭЭВЭР

Аймгийн тээврийн салбар нь 2019 онд 98.0 мянган тонн ачааг 85.6 мян.км зам туулан тээвэрлэлт хийсэн байна. Тус салбар нь 2019 онд 290.2 мянган хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос 51.5 хувиар буурч, зорчигч эргэлт 21 554.9 мян.хүн.км болж 37.7 хувиар буурсан байна. Тээврийн салбарын нийт орлого 2019 онд 1 117.7 сая төгрөгт хүрч өмнөх оноос 38.3 хувиар буурсан байна. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан авто машины тоо 2019 онд 16 315 болсон нь өмнөх оноос 5 096 (45.4%) машинаар өссөн байна.

ХҮСНЭГТ 6. ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН ТЭЭВРИЙН ТОО, төрлөөр

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019
Автобус	306	298	319	291	293
Ачаа	3 072	3 177	3 769	4 037	5 847
Суудал	4 184	4 849	6 237	6 767	9 941
Тусгай	78	80	78	124	234
Нийт	7 640	8 404	10 403	11 219	16 315

IV. ДҮГНЭЛТ

Аж үйлдвэрийн салбар нь манай аймгийн төдийгүй улсын эдийн засгийн хөгжилд голлох байр суурь эзэлдэг билээ. Сэлэнгэ аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 776.3 тэрбум төгрөг бөгөөд 376.5 тэрбум төгрөг буюу 48.5 хувийг аж үйлдвэрийн салбар бүрдүүлж байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар аж үйлдвэрийн салбарт 462.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийгдсэн нь урьд оны мөн үеэс 85.1 (22.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 62.7 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт, 35.2 хувь нь боловсруулах салбарт, 2.1 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт бүтээгджээ. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг сумдаар авч үзвэл Ерөө сум дангаараа аймаг нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 62.5 хувь буюу 288.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол Мандал сум 22.3 хувь буюу 103.3 тэрбум төгрөг, Сайхан сум 13.1 хувь буюу 60.4 тэрбум төгрөг, Сүхбаатар сум 1.4 хувь буюу 6.7 тэрбум төгрөг, бусад сумд 0.7 хувь буюу 3.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

Аж үйлдвэрийн салбарын 2019 оны нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг 2010 онтой харьцуулахад 301 (2.4*) тэрбум төгрөгөөр, 2014 онтой харьцуулахад 173.8 (50.9%) тэрбум төгрөгөөр, 2017 оноос 121 (30.7%), 2018 оноос 124.4 (31.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

2019 онд Сэлэнгэ аймагт 41 790.3 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь өмнөх оны мөн үеэс 28 573.7 сая төгрөг буюу 3.2 дахин өссөн байна.

Аймгийн тээврийн салбар нь 2019 онд 98.0 мянган тонн ачааг 85.6 мян.тн.км зам туулан тээвэрлэлт хийсэн байна. Тус салбар нь 2019 онд 290.2 мянган хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос 51.5 хувиар буурч, зорчигч эргэлт 21 554.9 мян.хүн.км болж 37.7 хувиар буурсан байна. Тээврийн салбарын нийт орлого 2019 онд 1 117.7 сая төгрөгт хүрч өмнөх оноос 38.3 хувиар буурсан байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ, НОМ ЗҮЙ

- Аймгийн 2019 оны жилийн эцсийн нийгэм, эдийн засгийн танилцуулга
- www.1212.mn сайт
- www.selenge.nso.mn
- www.nso.mn

Танилцуулгыг бэлтгэсэн: Б.Хулан / мэргэжилтэн/

Хянасан: Д.Гүндэгмаа / хэлтсийн дарга/